

Ур чадварын нэмэгдэл олгох журам
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт, Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63,А/73 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүрслэх урлагийн музейн албан хаагчдад “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг Нягтлан бодогч /А.Цэрэндолгор/ болон Хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Шинээр мөрдөгдөх “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулахыг Хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ

П. БАЙГАЛМАА

захирлын 20..... оны дугаар
сарын.....-ны өдрийн ... тушаалын
хавсралт

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙН АЛБАН ХААГЧДАД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дүрслэх урлагийн музейн ажилтнуудын ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Тус музейн ажилтнуудад сар бүр олгох ур чадварын нэмэгдэл хөлсийг Монгол улсын засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63,А/73 тоот тушаалаар батлагдсан “Шалгуур үзүүлэлт батлах тухай” журмыг үндэслэн олгоно.

1.3. Ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр нь захирлын тушаалаар баталгаажна.

Хоёр. Ур чадварын нэмэгдэл олгох зарчим

2.1. Захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ур чадварын нэмэгдэл олгох үнэлгээг сар бүрийн 15-нд албан хаагчийн ажлын тайланг үндэслэн дүгнэнэ.

2.2. Ажлын хэсэг албан хаагчийн ажлыг шалгуур үзүүлэлттэй хүснэгтээр дүгнэж, олговол зохих ур чадварын нэмэгдлийн хувийг тогтоон, зохих ур чадварын нэмэгдлийн хувь бүхий хүснэгтийг захиралд хүргүүлнэ.

2.3. Захирал хэлтсийн дарга нарын ажлыг дүгнэнэ. Хэлтсийн дарга нараас ирүүлсэн саналыг нягталж, ур чадварын нэмэгдлийг захирлын тушаалаар батална.

2.4. Тухайн сард ээлжийн амралтаа бүтэн авсан болон амралт дуусаж 3 өдөрт багтаж ажиллаагүй бол , байгууллагын дотоод журам болон ёс зүйн дүрэм зөрчсөн, сахилгын шийтгэл хүлээсэн, 2-оос дээш өдрөөр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохгүй.

2.5. Ажлын 3-аас дээш өдөр суралцахаас бусад шалтгаанаар цалинтай болон цалингүй чөлөө авсан бол ажилласан хоногоор тооцох, мөн сард 2 цаг 00 минутаас дээш хугацаанд ажлаас хоцорсон, ажлын цаг ашиглалтыг зөрчсөн бол 5 буюу түүнээс дээш хувиар хасаж олгоно.

2.6. Удирдах, Гүйцэтгэх, Туслах албан тушаалтанд олгох ур чадварын нэмэгдлийг Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63,А/73 тоот тушаалаар батлагдсан “Шалгуур үзүүлэлт батлах тухай” журмын дагуу олгоно.

2.7. Музейн ажилтныг музейн захирлаар батлуулсан удирдамжийн дагуу мэргэжлийн чиглэлээр дотоод, гадаадын байгууллагатай хамтарсан судалгааны ажилд оролцох, мэргэжлийн зэрэг дээшлүүлэх зорилгоор дотоод гадаадад сургалтад хамрагдах үед гүйцэтгэсэн ажлын чанарыг харгалзан тухайн сард олговол зохих ур чадварын нэмэгдлийг олгож болно.

2.8. Төлөвлөгөөт ажлаас гадна гэрээт захиалгын үндсэн дээр ажил гүйцэтгэж байгууллагад орлого оруулсан ажилтанд тухайн сарын ур чадварын нэмэгдлийг бүтэн олгож болно.

Гурав. Ур чадварын нэмэгдэл олгох үндсэн шалгуур үзүүлэлт

3.1. Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журам, хөдөлмөрийн гэрээний биелэлт, эрхэлж буй ажлын гүйцэтгэл

3.2. Бүтээлч санал, санаачилга гаргах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, эргэлтэд оруулах, музейн хөгжилд үр нөлөө үзүүлэх

3.3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, төсөл, хөтөлбөр, аяны хэрэгжилт

3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд нийцсэн орчин бүрдүүлэх, төрийн албаны болон салбарын ёс зүйн хэм хэмжээг баримтлах

3.5. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд идэвх санаачилгатай оролцох

Дөрөв. Бусад зүйл

4.1. Ур чадварын нэмэгдэл олгох хувь хэмжээ бүхий хүснэгтийг сар бүрийн 3 дахь долоо хоногт ирүүлнэ.

4.2. Захирлын тушаалыг үндэслэн тухайн сарын ур чадварын нэмэгдлийг сарын сүүлийн цалин дээр өгөхийг нягтлан бодогч хариуцна.